



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 14 өдөр

Дугаар А/525

Мөрөн сум

Барилга, байгууламж ашиглалтад
оруулах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Ханх сумын 3 дугаар багт баригдсан Хатуу хог хаягдлын ландфилл байгууламжийн ажлыг хүлээж авах ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Н.Шинэбаяр (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын
Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Л.Даваабаяр	(Ханх сумын Засаг дарга)
Д.Сандагдорж	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Ерөнхий архитектор)
Г.Ням-Эрдэнэ	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн сан хөмрөгийн эрхлэгч)
Д.Аюушжав	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)
Б.Гал-Эрдэнэ	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Мэдээлэл харилцаа холбооны хяналтын улсын байцаагч)
Д.Мягмарсүрэн	(Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга техник хяналтын улсын байцаагч)
Л.Бямбасүрэн	(Аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, дэд хурандаа)
Г.Даваадорж	(“Хөвсгөл эрчим хүч” ХХК-ийн Ерөнхий инженер)
Б.Цэнддэлгэр	(Аймгийн Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)
Ц.Бямбатөр	(Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын геодезийн мэргэжилтэн)

Захиалагч талын төлөөлөл:

Н.Оюун-Эрдэнэ (Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн
Барилгын инженер)

С.Аригуун (Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн
Хог хаягдлын менежментийн зөвлөх)

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:

Б.Эрдэнэболд ("Эн Эй Пи Групп" ХХК-ийн Зохиогчийн
хяналтын ахлах инженер)

И.Баасандулам ("Эн Эй Пи Групп" ХХК-ийн хог хаягдлын инженер)

Э.Гантулга ("Эн Эй Пи Групп" ХХК-ийн цахилгааны инженер)

Захиалагчийн хяналтын байгууллагын төлөөлөл:

Х.Даваасүрэн ("Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын
төв" -ийн захирал)

Э.Сумъяасүрэн ("Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын
төв" -ийн хяналтын инженер)

Э.Наранчимэг ("Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын
төв" -ийн хяналтын инженер)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

Б.Мөнхзул ("Хэмжилзүй" ХХК-ийн захирал)

Э.Энхболд ("Хэмжилзүй" ХХК-ийн инженер)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

Б.Баасансүрэн (Ханх сумын Засаг даргын тамгын газрын дарга)

Э.Бямбасүрэн (Ханх сумын Засаг даргын тамгын газрын нягтлан
бодогч)

Комиссын нарийн бичгийн дарга:

Д.Нямбат (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын
мэргэжилтэн)

2.Барилга байгууламжийн ажлыг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг олон нийтэд мэдээллэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Комиссын дарга (Н.Шинэбаяр)-д даалгасугай.

3.Барилга байгууламжийн ажлыг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Д.Нямбат)-д үүрэг болгосугай.

4.Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга байгууламж хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т үүрэг болгосугай.

ДАРГА

П. ЛХАГВАЖАВ

